



СЭЛЭНГЭ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 07 өдөр

Дугаар 102

Цагаантолгой

Хорио цээрийн дэглэмийг цуцалж,  
хязгаарлалтын дэглэмд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 –ын 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 18.1, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”-ын 2.1, 2.8 дахь заалт, сумын Онцгой комиссын 2022 оны 1 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдааны шийдвэр, сумын Мал эмнэлгийн тасгийн саналыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын нутаг дэвсгэрт бүртгэгдсэн мал, амьтны гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх зорилгоор тогтоосон Хорио цээрийн дэглэмийг 2022 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр цуцалж, мөн өдрөөс эхлэн Хязгаарлалтын дэглэмд шилжүүлсүгэй.

2. Хязгаарлалт тогтоосон хугацаанд холбогдох журам, зааварт тусгагдсан арга хэмжээг чанд сахиулж урьдчилан сэргийлэх арга хэмжээ, бэлэн байдлыг хангаж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Б.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга (А.Одхүү)- д даалгасугай.



С. ШИЖИРБААТАР

Боловсруулсан: Т. Амбал  
Хянасан: С. Шалмыраал  
Хувь: 2.  
Огноо: 2022.01.07